

## Дафа-гийн шавь гэж юу гэсэн үг вэ

2011 оны Нью-Йоркийн Фа чуулган дээр заасан Фа  
Ли Хонжи ~ 2011 оны 8-р сарын 29

(Багш танхимд орж ирэхэд бүгд босож, нижигнэтэл алга ташив)

Өглөөний мэнд. Та нар бүгд шаргуу ажиллаж байлаа. (Шавь нар хариуд нь, “Багш шаргуу ажилласан”) Би биш, та нар үнэхээр шаргуу ажилласан. (Бүгд инээв) Сууцгаана уу.

Дафагийн шавь нар маш шаргуу ажилладаг нь эргэлзээгүй. Учир нь та нарт хүлээлгэсэн түүхэн үүрэг хариуцлага байгаа, та нар үүнийг үнэхээр сайн биелүүлж байна, та нар энэ эгзэгтэй цаг үед энэхүү түүхэн үүрэг хариуцлагаа биелүүлэх ёстой гэдгийг та нарын түүхэн эрхэм зорилго хэлж байна. Дафагийн шавь нар сансар ертөнцийн үүсэх, тогтох, доройтох, сүйрэх мөчлөгийн яг эцсийн шатанд гарч ирцгээсэн. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл, амь бодь ч бай, материаллаг биет ч бай, энэ үед бүх зүйл хамгийн сүүлчийн бөгөөд хамгийн муу цэгтээ хүрсэн. Аливаа зүйлсийн илрэл нь хамгийн төвөгтэй байдалтай болсон, сайн ба мууг, эсвэл нинжин ба харгисыг ялгах нь хамгийн хэцүү болсон. Ийм цаг үед Дафагийн шавь нарт түүхэнд хүлээсэн эрхэм үүргээ биелүүлэхэд үнэхээр хэцүү байгаа. Би Дафа-гийн шавь нар бол ер бусын гэж хэлж байгаа нь, ийм цаг үед амь бодиудыг аврах, Багшид Фа-г засахад нь туслах, мөн хүн бүр даалгавраа биечлэн биелүүлэх гэж ирсэн учраас юм, энэ бол та нарыг үнэхээр онцлог болохыг харуулж байна. Түүхийн ямар ч эрин үеийг энэ үетэй харьцуулшгүй.

Би өмнө нь Шагжамүни, Есүс, Лаози гэх мэт болон түүнчлэн бүр ч эрт дээр үед дэлхийд ирсэн хэд хэдэн агуу сэтгэгчид, гэгээнтнүүд, агуу бурханлаг оршихуйнууд бүгд түүхийн явцад гагцхүү хүн төрөлхтний соёлыг л бий болгож байсан гэж ярьж байсан. Тэдний заасан бүх зүйл, үзүүлсэн аврал, хийсэн зүйлс нь хүн төрөлхтний соёлд байх ёстой зүйлийг л үлдээх явдал байсан юм. Тэдний жинхэнэ авч явсан хүмүүс бол тэдэнд энэ соёлыг түгээхэд нь туслахын тулд тусгайлан илгээгдсэн амь бодиуд байсан, гэхдээ зөвхөн тэдгээр хүмүүсийн Дэд сүнснүүд байсан бөгөөд тэд нь хэзээ ч хүний ертөнцөд нэвтэрч орж ирээгүй юм. Түүхийн эцсийн, эгзэгтэй энэ мөчид ийм зүйлсийг үнэхээр хийж чадах хүмүүс бол зөвхөн Дафагийн шавь нар юм. Дафагийн шавь нар гарал үүслээсээ эхлүүлэн түүхийн туршид агуу буян хураах үйл явц хүртлээ үүрч ирсэн ачаа нь өнгөрсөн үеийн гэгээн хүмүүсээс ч илүү их юм. Шалтгаан нь, энэ эцсийн үе бол жинхэнэ зүйлс хийгдэж байгаа үе юм. Эрт дээр үеэс өнөөг хүртэл, сансар ертөнцийн эхэн үеэс жараад жилийн өмнөх хүн төрөлхтний эцсийн бүлгийн үе хүртэл, бүх зүйлс Фа цэвэрлэгээ хийхэд шаардагдах суурийг тавихад, мөн түүхийн эцсийн үе шатанд оролцох хүмүүст туршлага хуримтлуулах, сэтгэхүй зан байдлаа төлөвшүүлэх явцад үргэлж үйлчилсээр ирсэн. Хүн төрөлхтний түүхийн явц ийм л байсан. Дафагийн шавь нар ч бай, тэдэнтэй ямар нэгэн холбоотой амь бодиуд ч бай бүгд энэ хэргийн төлөө үйлчилж ирсэн, тэдний төрөл олох явцад аливааг туршиж үзэж, хүн тус бүрт шаардагдах зүйлсийг бий болгосон. Фа цэвэрлэгээтэй шууд холбоогүй байдаг сансар ертөнцийн хэмжээлшгүй, тоо томшгүй олон амь бодиуд аврагдах ёстой амь бодиудад тооцогддог; тэд [Фа-цэвэрлэгээнд] ямар нэг

үүрэг гүйцэтгэдэггүй. Миний саяны тайлбарласан бол Фа-цэвэрлэгээтэй холбоотой оролцогчид юм.

Та бүхэн мэдэж байгаа, Фа-цэвэрлэгээтэй холбоотой бүх амь бодиудыг хамарсан энэ дэлхий ертөнц дэх хүмүүс энгийн биш гэдгийг би өмнө нь хэлсэн. Бүгд Фа-цэвэрлэгээний төлөө энд ирсэн, Фа-цэвэрлэгээний төлөө бий болсон, Фа-цэвэрлэгээний төлөө бүтээгдсэн. Юу ч санамсаргүй байдаггүй бөгөөд ирээдүйд та нар үүнийг харах болно. Хүний ертөнц дэх төөрөгдөлийн дунд хүмүүс түүхийн туршид янз бүрийн хэлбэрийн нийгмийг туулж ирсэн бөгөөд үүнийг тэд жирийн хөгжлийн жам ёсны үйл явц гэж боддог. Гэхдээ тэр тийм биш. Цаг үе болгон цаанаа учир шалтгаантай байдаг. Та бүгд мэднэ, Бурхад анх хүнийг бүтээхэд хүний сэтгэхүй нь байгаль орчин болон нийгэмтэй харьцах чадваргүй, амьдрах чадвар маш дорой байсан гэж би хэлсэн. Хүмүүс анх бүтээгдэхдээ юу ч ойлгодоггүй байсан учраас аянгын чимээнээс айхдаа агуйд нуугдах гэж сандран гүйлддэг байсан; эсвэл бороо ороход тэр яаж хоргодохоо ч мэдэхгүй, эсвэл бүр юу болоод байгааг ч мэддэггүй байсан. Тиймээс цаг хугацаа өнгөрөх тусам түүхийн явцад хүн байгаль орчинтойгоо хэрхэн харьцахаа аажмаар мэддэг болсон. Дараа нь Бурхад хүн төрөлхтөнд төрөл бүрийн соёл тасралтгүй дэлгэрүүлж тэдгээр соёл нь хүмүүнд хэрхэн нөлөөлөхийг ажиглаж байсан. Өөрөөр хэлбэл, энэ нь туршилт болон алдааны тасралтгүй үйл явц байсан бөгөөд тэдгээр зүйлийг амьдралд хэрэгжүүлэх, эцсийн үр дүнд тодорхой үе шатанд бүрэн дуусган шийдвэрлэсэн. Аливаа юмсыг эцэслэн шийдвэрлэх явц маш урт удаан хугацааны турш үргэлжилсэн бөгөөд эцсийн шатанд шаардлагад нийцэх сэтгэлгээ, зан төлөвийг бий болгоход тохиромжтой соёл болон хүн төрөлхтний соёлын шилдэг зүйлсийг сонгосон. Эдгээр нь эцсийн хүн төрөлхтний орших таван мянган жилийн хугацаанд ашиглагдаж хүнээр хэрэгжих ёстой байсан. Энэ бол миний хэлж байгаа Хятадын таван мянган жилийн соёл иргэншил юм. Энэ бол удаан хугацаанд үргэлжилсэн түүхэн үйл явцад үүссэн бүтээгдэхүүний үр дүн оргил үе юм. Энэ үйл явц нь хүмүүст ямар сэтгэлгээний хэв маягийг ашиглах, ямар сэтгэлгээний бүтцийг бий болгох, тулгарч буй зүйлсийнхээ талаар хэрхэн бодох, аливаа зүйлийг эргэцүүлэн бодоход ямар сэтгэлгээний арга хэрэглэхийг зааж өгөх зорилготой байсан.

Хүний сэтгэлгээ бодол нь түүний үйлдлийг шууд удирддаг. Жишээлбэл, бид Хятадын Гурван хаант улсын үеийн Вэй, Шу, Ву зэрэг улсуудыг мэддэг. Гурван хаант улсын түүх ямар тодорхой соёлын шинж чанарыг гаргасан бэ? “Шударга ёс.” Түүхийн тэр үеийн хүмүүс “Шударга ёс” гэж юу болох, “Шударга ёс” гэдэг нь хэрхэн илэрдэг, “Шударга ёс” гэдэг үгийн гүн утгыг мэддэг болсон. Өмнөд Сон гүрний Юэ Фэй юуны суурийг тавьсан бэ? “Үнэнч” (Үүнд үүсэл нь багтдаг) “Үнэнч” гэдэг нь юу гэсэн үг вэ, “Үнэнч” гэдэг ойлголт юуг агуулж байдаг, энэ нь хэрхэн явагддаг, түүнд хэрхэн хариулах, хариу үйлдэл үзүүлэхийг багтаасан болно. Түүхийн явц нь хүмүүст хэрхэн хүн байхыг заах үйл явц байсан юм. Хүн төрөлхтний энэ таван мянган жилийн түүхийн бүхий л зам нь хүмүүнд шаардлагатай зүйлсийг бий болгох тасралтгүй явц байсан. Сүүлчийн үе шат ирэхэд хүний үзэл бодол нь хангалттай төгс, зөв болж Бурхадын санаанд дүйхүүц хэмжээнд хүрэхэд, тийм хүнийг эцсийн түүхэн мөч дэх шийдвэрлэх үед ашиглаж болохоор болсон. Гэхдээ нэг асуулт хэвээр байна. Та нарын төсөөлж байгаагаар миний тайлбарласан зүйл бол хагас бурханлаг соёлтой хүмүүс, бурхадаар шууд бүтээгдсэн хүмүүсийн тухайд юм. Үүнээс үүдээд ийм хүний эсвэл энэ хүний соёлын агуулсан эерэг элементүүд сөрөг элементүүдээс давуу байх болно. Хүн төрөлхтөн сансар ертөнцийн эерэг ба сөрөг элементүүдийг аль

алиныг нь агуулж байдаг, Гурамсан ертөнц дэх бүх бие бодид сайн, муу элементүүд байдаг, Бурхад Гурамсан ертөнцийн бие бодийг ашиглан хүнийг бүтээхэд түүний дотор жамаараа сайн ба муу элементүүд агуулагддаг. Хүн ухаангүй загнахад эсвэл уур уцаар нь дүрсхийхэд, энэ нь үнэндээ чөтгөрийн мөн чанар нь гарч ирж байгаа юм; мөн хүн эелдэг, ухаалаг байхад, эргэн тойронд болж буй бүх зүйлд эелдэг байдлаар хандаж байхад түүний сайн элементүүд гарч байдаг, түүний Буддын мөн чанарыг харуулж байгаа юм. Тиймээс, хүмүүст эдгээр хоёр төрлийн элемент байдаг, гэхдээ энэ нь дангаараа бол хангалтгүй юм.

Хүнийг бүтээх үйл явц эерэг гэдгийг би сая хэллээ. Бүх хүмүүсийн төрөлх зан нь эелдэг, зөв бодолтой байдаг. Тэгвэл боддоо, Фа-засах үед намайг Дафа-г түгээхэд ийм хүмүүсийн 100 хувь нь хэзээ боломжтой болонгуут ямар ч асуудалгүйгээр бүгд Фа олж авахыг хүсэх байсан. Энэ нь ялангуяа Хятад хүмүүсийн хувьд бүгд ирж Дафа-д суралцаж, бясалгах байсан юм. Надад их ярих шаардлагагүй, тэр даруйдаа дэлгэрч хаа сайгүй тархах байсан. Гэхдээ та бүхний мэдэж байгаагаар, сансар ертөнц аймшигт байдалд хүрсэн бөгөөд энэ эрин үеийн амь бодиудын төгсгөл болох ёстой; гэвч энэ ертөнцийн амь бодиудыг санаатайгаар өнөөгийн ийм дүр төрхтэй болгосон. Мөн энэ хэрэгт оролцож буй эдгээр хүмүүсийн ард асар том бүлгүүдийн амь бодиуд байж байдаг. Амь болгон, хүн болгон энгийн биш юм. Тэдний ард тэдний төлөөлдөг сансар ертөнцийн асар том бүлгийн амь бодиуд байдаг. Нэг хүн авралыг олж авбал энэ нь ард нь байгаа түүний төлөөлдөг бүх амь бодиуд ирээдүйд авралыг олж авна гэсэн үг. Би үүнийг ярьж байгаа учир нь энэ дэлхий дээрх хүмүүсийн дийлэнх нь, өнөөгийн хүмүүсийн дийлэнх нь дэлхий дээр бууж ирсэн, энд хүн болж төрөл олсон тэнгэрийн хаадууд юм. Тиймээс, хэрэв эдгээр бүх амь бодиуд ирж, Дафа-д суралцсан бол, тэд бүгд, мөн тэдний төлөөлж буй бүх амь бодиуд аврагдах байсан. Ийм байвал мэдээж сайн хэрэг байх байлаа, мэдээж энэ сансар ертөнц дахь ямар ч амь бодь, мөн тоо томшгүй олон, асар том хаадууд санал нэг байх байсан. Гэсэн хэдий ч эцсийн Бүтээгч үүнийг тэгж хардаггүй. Ямар нэг зүйл муудвал тэр устгагдах ёстой. Түүний хувьд шинээр зүйлийг бүтээх нь муу зүйлийг устгахтай адил амархан юм. Сансар ертөнцөд нэг зарчим байдгийг та нар мэдэж байгаа: энэ нь, сайн ба муу нь өөрийн үр дагавартай байдаг. Муу зүйл хийсэн хүн түүнийхээ төлөөсийг төлөх ёстой гэсэн үг юм. Сайн үйлс нь ивээлтэй хариу дагуулдаг бол муу үйл нь сөрөг үр дагаварт хүргэдэг. Зорилго нь асуудлыг зохицуулах явдал юм. Гэвч түүхийн урт хугацааны туршид амь бодиуд бусад амь бодиудтай харилцахдаа зөвхөн үйлийн үрийн өртэй болоод зогсохгүй, бас олон амь бодиуд өөрийн мэдэлгүй орчлон ертөнцийн түүх уруудахад хувь нэмрээ оруулсан бөгөөд үүнд бараг бүх амь бодиуд тодорхой үүрэг гүйцэтгэсэн. Бүх муу болсон зүйлсийн бурууг хүн бүр хуваалцдаг. Бүх зүйл аажмаар улам дордсоор байгааг бүгд ойлгож байсан ч хэнд ч энэ урсгалыг эргүүлэх чадвар байгаагүй. Хэн бүхэн энэ үйл явцад оролцсон болохоор доош уруудах эргэлтэнд хамт явж байна. Өөрөөр хэлбэл, “үүсэх, тогтворжих, доройтох, сүйрэх” хуулийн дагуу бүх зүйл сүйрэл рүүгээ чиглэх ёстой байдаг. Энэ бол сансар ертөнцийн хууль юм. Энэ нь нигүүсэл сэтгэлийн асуудал биш. Энэ бол зүгээр л хууль.

Та бүхэн мэдэж байгаа, матери-бие бодь мөхдөггүй, амь бодь дахин төрөл олж төрдөг гэж би заасан. Мөн зөвхөн хүн ийм байдаггүй, бурхдын ертөнцөд ч гэсэн ийм байдаг. Төөрөгдөлд автсан хүн үүнийг харж чадахгүй тул, үхлийг аймшигтай гэж үздэг. Мэдээж, Дафа-гийн шавь нарын хувьд иймэрхүү зүйлийг ойлгодог болсон. Хүний молекулын эсүүдийг бүрдүүлдэг молекулууд нь атомуудаас бүрддэг ба атомууд нь бүр ч бичил

бөөмсүүдээс бүрддэг, мөн бөөмс нь илүү бичил байх тусам энерги нь улам их байдаг. Хүний биеийг газарт булахад, түүний гадаргуйн давхарга дахь молекулуудаас бүрддэг эсүүд нь ялзардаг гэдгийг бид мэднэ. Гэхдээ молекулууд ялзардаггүй, тийм биз? Тэгвэл атомууд бүр ч ялзарахгүй, тийм үү? Тэгэхээр чиний тэр хэсэг хаашаа явсан бэ? Хэрвээ хүний бодол санаа нь зүгээр л энэ гадаргуйн давхарга дахь өөрийн оюун сэтгэхүйн бүтээгдэхүүн байсан бол, хүмүүсийн заримдаа санаандгүй байдлаар хэлдэг зүйлийг юу гэж тайлбарлах вэ? Чиний хэлж буй зүйлс зөвхөн сайтар тунгаан бодож байж л гарч ирдэг зүйл биш, үргэлж ийм байдаггүй; харин энэ нь заримдаа янз бүрийн түвшинд байгаа чи оролцдог, гадаргуйн давхарга дахь чиний ширхэгүүдээс авхуулаад бичил ертөнцийн гүн дэхь ширхэгүүдээс нэгэн зэрэг бүрддэг, олон чи ажиллаж байдаг юм. Чиний оршихуй бүхэлдээ хамгийн бичил сансар ертөнцийн түвшний ширхэгүүдээс аваад гадаргуй хүртэлх ширхэгүүдийг багтаасан байдаг тул чиний оршихуй бол зүгээр нэг маш энгийн зүйл биш, эсүүдийн гадаргуйн давхарга биш юм. Хүний оршихуйн хувьд, энэ гадаргуйн хэсгийг алдах нь зөвхөн гаднах арьсны давхаргыг алдаж байгаа хэрэг юм. Дахин төрөл олоход шинэ гаднах арьс олж авдаг. Харин жинхэнэ чамайг газарт булж ялзруулж чадахгүй. Хөрс бол атом битгий хэл молекулуудыг ч задалж чадахгүй. Хэрэв хүний биеийн атомууд задарвал асар том дэлбэрэлт болно. Хүний биеийн хүрэн дэх цөмийн дэлбэрэлтийн хүч нь хотыг сүйрүүлэхэд хангалттай байх болно. Энэ үнэн биш гэж үү? Тэгвэл чи (үхэх үедээ) хаашаа явдаг вэ? Дафа-гийн шавь нар хариултыг мэднэ. Тиймээс, энэ ертөнцийн хуурмаг байдлын дор, хүмүүс нас барсныхаа дараа тэдэнд юу тохиолдохыг мэддэггүй гэсэн үг юм. Гэвч бурханлаг оршихуйнууд юу болдгийг маш сайн мэддэг, мөн бүр өндөр түвшний бурханлаг оршихуйнууд бүр ч сайн мэддэг. Тэд энэ бүхнийг жам ёс гэж үздэг. Аливаа амь бодь амьдралынхаа эцсийн алхамыг хийх үед, шинэ амьдрал нь бий болдог. Тэд энэ үйл явцыг бүрэн мэддэг. Ийнхүү миний яриад байгаа 'ирж буцдаг' үйл явц бүхэл орчлон ертөнцөд явагддаг.

Миний тайлбарласан зүйл бол төгсгөлийн өмнөх үеийн агуу сансар ертөнцийн түүхэн үйл явц, түүний доторх тоо томшгүй олон давхаргын амь бодиудын хөгжлийн явц нь тасралтгүй солигдох бодисын солилцооны үйл явцтай төстэй юм. Гэвч хэрэв эцсийн сансар ертөнц, өөрөөр хэлбэл энэ оршихуй үүсэх, тогтнох, доройтох, сүйрэх үйл явцын нэг хэсгийн адил бүхэлдээ мөхөж задралд орвол, тэгвэл бодоод үздээ: Хэрэв түүнд агуулагдах амь бодиудын давхрагууд дахин төрөл олж чадахгүйд хүрвэл, тэдний түүх оршин тогтнохоо больж тэдэнд амь, юу ч байхгүй болох байсан. Бурхадуудын хувьд, тэдний бүтээлийн орон хэр өндөр байсан ч энэ бол үнэхээр аймшигтай! Энэ бол үнэхээр туйлын аймшигтай зүйл бөгөөд бүрмөсөн устгагдах болох юм! Агуу сансар ертөнцийн түүхэн хөгжлийн үйл явц нь маш их гайхамшигтай зүйлсээр баялаг! Хүн төрөлхтний энэ жижигхэн гариг дээр ч гэсэн бүх зүйл ямар байгааг хар даа. Тэгвэл, янз бүрийн хэмжээтэй ширхэгүүдээс тогтсон сансар ертөнцийн тоо томшгүй олон гаригуудыг авч үзье, тэдгээрт хязгааргүй олон, хэмжээлшгүй их амь бодиуд байдаг. Бурхад ч гэсэн тэнд хичнээн амь бодиуд байгаа болохыг, ямар гайхамшигт зүйлс тэнд бүтээгдсэнийг олж мэдэж чадахгүй! Хүн бүр түүхийн нэгэн шаштир гэсэн үг. Хүн бүр түүхийн урт домог мэт байдаг. Аливаа хүний олон амьдралынх нь туршид туулж өнгөрүүлсэн бүх зүйлсийг харахад үнэхээр гайхалтай. Сансар ертөнц бол асар уудам, үүнд орших амь бодийг тоолхын аргагүй, гэтэл энэ бүгдийг устгана гэвэл тун харамсалтай байх байсан!

Мэдээж, энэ нь сансар ертөнцийн хууль байж болох ч, нинжин сэтгэл бол ариун Бурхдын нэгэн шинж чанар юм. Зүгээр нэг сайн зүйл хийхийг хүсэх нь нинжин сэтгэлд тооцогддог гэсэн үг биш юм. Хэн нэгэн дур сонирхолдоо хөтлөгдөж, түүндээ нийцүүлэн аливаа үйлийг хийвэл, энэ нь нинжин сэтгэл гэж тооцогдохгүй. Харин энэ нь тухайн хүний таалалд нийцсэн учраас юм. Эсвэл бүр шулуухан хэлвэл, энэ нь зууралдсан сэтгэл юм. Жинхэнэ нинжин сэтгэл гэдэг нь ямар ч хувиа хичээсэн сэтгэлтэй огтхон ч холилдоггүй бөгөөд хэнтэй ч, ямар ч амь бодтой харьцахдаа зөв бодол, хайр энэрлээр ханддаг. Ийнхүү сансар ертөнцийн туйлын өндөр түвшний янз бүрийн давхаргын олон Бурхдууд, олон хаадууд, орчлон ертөнцийн төгсгөлийг хараад орчлон ертөнцийн амь бодиудыг аврахыг хүссэн юм. Тэгвэл тэд яаж аврах гэж? Фа-цэвэрлэгээний замаар шинэчлэлт нь сансар ертөнцийн хамгийн доод давхрагаас эхэлж, доороос дээш хүртэл засах ёстой. Энэхүү сансар ертөнцийн маш олон төлөөлөгч амь бодиудыг хүн болж төрөл олохоор явахыг зөвшөөрсөн. Гэхдээ төлөөлөх үүрэг гүйцэтгэх чадвартай амь бодиуд нь жирийн нэг дундаж амь бодиуд биш юм. Тэд бол гарцаагүй өөр өөр орчлон ертөнцийн хаадууд бөгөөд тэд өөрсдийн ертөнц, орчлон ертөнцүүдийг эсвэл сансарын биетүүдийг төлөөлдөг. Гэхдээ ийм амь бодийн төлөөлж буй орчлон ертөнц нь тодорхой системд хамаарагддаг. Сансарын биет нь доод орчлон ертөнцүүдээс дээд орчлон ертөнцүүд рүү явсан эргэлттэй байдаг, энэ систем нь тэднээс ч агуу хаадуудтай бүр дээд давхрагуудын системүүдтэй зохилдсон холбоотой байдаг. Мөн тэдгээрээс ч дээд давхаргын системүүдийн дээр бүр ч агуу системүүд болон хаадууд байдаг. Гэхдээ хэр өндөр байх нь хамаагүй бүгд нэг системд харьяалагддаг. Гэвч хамгийн өндөрт байдаг тэр нэгэн энд ирэхгүй байж магадгүй юм. Тэгвэл яах вэ? Тухайн асар том систем дэх тоо томшгүй олон амь бодиудыг төлөөлөх нэлээд тохиромжтой төлөөлөгчийг илгээж, хүн болгож төрөл олуулах юм.

Би үүнийг та нарт тайлбарлаж байх зуур та нар ингэж бодож магадгүй юм, "За, миний харж байгаагаар, энэ дэлхийн хүмүүст агуу гайхалтай гэх юу ч алга. Янз бүрийн хэлбэр, дүрстэй хүмүүсийг харж болно, зарим нь бүр хааш яаш байдаг. Хөдөөний зарим хүмүүс үнэхээр хэцүү амьдралд байхад, хотынхон дэндүү ямбатай, тааруухан зан ааштай, мөн маш олон залуучууд "их дажгүй" харагдахыг хичээдэг." Энэ бол зүгээр л хүний нийгмийн хэв маяг юм. Хүн бүр томоохон корпорацид ажиллаж чадахгүй, эсвэл босс болж чадахгүй, тиймээс зарим хүмүүс бусад үүргийг гүйцэтгэх ёстой байдаг. Цөөн тооны хүмүүс л жүжигчид, од болж чадна. Бусад бүх зүйлс ч ялгаагүй адилхан. Нийгмийн өөр өөр анги давхарга байх нь хүний нийгэмд байдаг хэлбэр боловч эдгээр нь тэдгээр амь бодиудын зэрэглэл биш юм. Тиймээс гаднах төрх байдлаас үл харгалзан ямар ч амь бодь энгийн биш. Хэрэв чи хог цэвэрлэдэг хүний өмнөх амьдралуудыг нь эргэж харвал, урьд өмнө нь сансар ертөнцөд асар том бурхан байсан. Гэхдээ энд төөрөгдлийн дунд байхдаа болон төрөл олох явцдаа тэр юу ч санахгүй болтлоо бүрэн төөрсөн байдаг. Төөрөгдөлд, ийм олон амь бодиуд төрөл олох явцдаа амьдралынхаа хувь заяанд хүртэл гомддог, тэднийг энд авчирсан зорилгын талаар юу ч мэддэггүй.

Энэ нь бол зөвхөн нэг жишээ юм. Өнөөгийн энэ ертөнцийн хүмүүс, тэр дундаа нийгмийн янз бүрийн давхаргын ихэнх хүмүүс энэ ертөнцөд юуны төлөө ирсэнээ мэдэхгүй, ажил албан тушаал хөөх нэрийдлээр завгүй байдаг. Ялангуяа жоохон амжилтанд хүрсэн хүмүүс өөртөө сэтгэл хангалуун байдаг, өөрийгээ хэн болохоо мартдаг. Мөн тэд өөрсдийгөө зарим зүйлд үнэхээр сайн гэж бодох үед түүндээ бүрмөсөн автдаг; амьдрал нь тийм ч сайн биш бол, тэд шударга бус байна гэж үзэн хорвоод уурлаж

гомдолдог. Гэвч үнэндээ энэ нь чиний амьдралд шаардлагатай зүйл биш. Та нар иймэрхүү зүйлд автаж болохгүй. Үүний оронд хамгийн чухал зүйл бол жинхэнэ өөрийгөө сэргээх явдал юм. Энэ цаг үед, түүхийн их явцад хүний амьдралд болж буй зүйл нь цаанаа учир шалтгаантай байдаг. Шулуухан хэлэхэд, өнөөдрийн амьдралд чинь илэрч байгаа зүйлс бол чиний өмнөх амьдралууддаа хийсэн аливаа сайн эсвэл муу үйлийн хариу юм. Миний сая хэлсэнчлэн сансар ертөнцөд ийм зарчим үйлчилдэг. Чи нийгмийн аль ч давхаргад, ямар ч ажил мэргэжилтэй бай хамаагүй, сайн зүйл сайнаар, муу нь муугаар хариулагддаг. Энэ хууль Гурамсан ертөнц даяарх аль ч түвшинд оршдог. Тиймээс, эцсийн шатанд хүрч ирсэн энэ үед хүний бодол, ялангуяа сансар ертөнцийн үүсэх, тогтнох, доройтох, сүйрэх мөчлөгийн эцсийн шатанд байгаа хүний нийгмийн энэ үед бүр төвөгтэй болсон. Иймээс энэ цаг үед дэлхийн хүмүүсийг энэхүү ээдрээтэй орчинд сэрээж тэднийг аврахад Дафа-гийн шавь нар л хэрэгтэй байна.

Одоо энэ бүгдийг улам бүр хүндрүүлж байгаа нь Хятадад оршиж буй харгис, голдоо хүртэл хорон болсон ХКН-ын дэглэм юм. Хүн төрөлхтний нийгэмд, ялангуяа ийм гажсан дэглэм яагаад гарч ирэх болов? Сансар ертөнцийн дээрээс доош хүртэлх хэн бүхэн, үүнийг эсэргүүцдэг. Тэд бүгд үүнийг ад чөтгөрийн гэж үздэг. Хорон санаат намын гишүүдийн үзэл бодол хэвийн биш. Тэгвэл юуны тулд оршиж байна вэ? Ямар ч зүйл харагддаг шигээ энгийн байдаггүй. Энэ нь мөн л сансар ертөнцийн хуучин хүчнүүдийн санаатайгаар төлөвлөсөн зүйл юм. Хүний соёл бол хүн төрөлхтнийг бүтээх үйл явц дахь Бурхадын зохицуулалт гэж би түрүүн хэлсэн. Жинхэнэ сонгодог соёл бүрэлдэн тогтсоны дараа, хүмүүсийн бодол бүхэлдээ зөв шударга, сэтгэлийн гүнээсээ эелдэг зан чанартай, мөн хүн бүр хийж буй үйлдэлдээ бусдыг боддог байх байсан юм. Ийм хүмүүс эцсийн шатанд ирсэн байсан бол, бүгд эерэг сонголт хийх байсан. Хүн бүр Фа-г олж авах байсан. Гэвч сансар ертөнцийн хуучин хүчнүүдийн хувьд, хүмүүс Фа-г олж авах, амь бодиуд аврагдах нь дэндүү амархан санагдсан юм. Гурамсан ертөнцөд "сайн муу нь өөрийн үр дагавартай" гэдэг хууль байдаг тул, зарим Бурхад ийм хэтийн төлөвлөгөөг тэвчиж чадалгүй энэ зарчмыг туйлшруулсан. Тэдний бодол: "Сансар ертөнц сайн байхаа больсон, тиймээс амь бодиудад ийм амархан байдлаар яаж аврал үзүүлж болох юм? Яаж ийм олон амь бодиудыг ирээдүйд оруулахыг зөвшөөрөх юм бэ?" Тиймээс асар их, өргөн хэмжээний хүчин зүйлс амь бодиудыг аврагдахад саад болсон. Хуучин хүчнүүд ингэж бодож байгаа нь хуучин сансар ертөнцийн Фа зарчмууд доройтол, сүйрлийн шатандаа хүрснийг харуулж байна. Хуучин хүчнүүд эцсийн үйл явцын үеэр амь бодиуд сонголтоо хийх ёстой гэж шийдсэн, гэвч энэ сонголт нь хийхэд туйлын хэцүү, учир нь бүх зүйлийн төгсгөл болох ёстой, үүнээс гадна дэлхийн ёс суртахуун эмх замбараагүй болсон. Ирээдүйд орохыг хүсч байгаа хүмүүс сонголтоо хэрхэн хийх ёстой гэж? Энэ бол туйлын хэцүү. Энэ босгыг маш өндөр тогтоосон.

Зарим хүмүүс “Бурхад, Будда нар хүмүүст энэрэнгүй ханддаг биз дээ?” гэж боддог. Хүн төрөлхтөн ийм хэмжээнд хүрчихээд байхад, хүний бодлоор ийм асуудлыг цэгнэж болохгүй. Хуучин хүчний Бурхад тэгж боддоггүй нь лавтай. Хэрэв та нар аврагдахыг, авралыг олж авахыг хүсч байвал өнөөгийн нийгмийн энэ янз бүрийн уруу таталтын дунд зөв сонголт хийх ёстой. Ингэж байж л та нар сорилтыг даван туулах болно. Хэрэв та нар давахгүй бол, аврагдахгүй. Та нар санаж байгаа байх, би "Торыг нээх" гэж байнга хэлдэг байсан. Хэрвээ хүмүүс өөрсдөө сорилтыг давж гарах бол, яаж ингэж чадах билээ? Хуучин хүчнүүд ингэж хийнэ гэдгийг нь Багш эртнээс мэдэж байсан учраас би Дафа-гийн шавь

нарыг амь бодиудыг аврахаар зохицуулсан. Хуучин хүчнүүд амь бодиудад хүндрэл учруулах зорилгоор энэ дэлхийд хорон муу намын дэглэмийг бий болгосон юм. Үүний зэрэгцээ тэд олон тооны солиотой онол, орчин үеийн санаанууд гэх мэтийн зүйлсийг гаргаж сайн, мууг хольж энэ дэлхийг аймшигтай ээдрээтэй болгосон. Түүнчлэн тэд хүний уламжлалт, зөв зохистой бодлыг алдагдуулахын тулд энэ холимогт зарим гажуудсан хүчин зүйлүүд болон харь гаригийнхны биотехнологийг нэмж оруулсан. Барууны нийгэмд бол, тэдэнд харгис муу, хор хөнөөлтэй зүйлсийг бий болгож тавихад л хангалттай байсан. Гэвч Хятадад энэ нь хангалттай биш байсан. Тэд үүнийг улам лавшруулж, зөвийг буруу болгож, мууг сайн болгон хувиргасан. Ийм хэцүү нөхцөлд хүн аврагдах эсэхээ шийдэх сонголт хийх ёстой гэсэн санааг агуулсан юм. Тэгвэл яагаад Хятадад бүх зүйлийг ийм хэцүү болгосон юм бэ? Бүр өндөр түвшний хаадууд, түүхийн турш дахь хүн төрөлхтний үндэстэн ястан бүрийн хаадууд, сансар ертөнцийн дээд түвшнөөс ирсэн бүгд Хятадад хүн болж төрсөн тухай би урьд нь ярьж байсан. Энэ нь гол төв цэг болсон юм. Тийм ч учраас тэндхийн хүмүүст сонголт хийхэд тулгарах хүндрэлийн зэрэг нэмэгдсэн. Учир нь ийм хүмүүс авралыг олж авмагцаа тэдний төлөөлж буй угсаатны бүлэг, тэр байтугай зарим тохиолдолд тэдний төлөөлж буй асар том орчлон ертөнцийн бүхэл бүтэн бүлэг аврагдах болно гэдгийг хуучин хүчнүүд харсан юм. Энэ нь ямар том зүйл болохыг бодоод үз дээ. Тиймээс хуучин хүчнийхэн эдгээр хүмүүст тулгарах хамгийн том сорилтуудыг хийсэн. Хятадуудыг хараад байхад, сүүлийн үед гадаад төрх нь хүртэл намхан болж жижгэрч, зүс царай муутай болсон, ийм хэмжээнд хүртлээ доройтож муудсан. Түүхэнд хүмүүс үргэлж эрүүл сайхан төрхтэй, сайн талаар яригддаг байсан. Тэд маш сайхан харагддаг байсан. Сүүлийн үед хүмүүст муу муухай зүйлс суулгаж байгаагаас Хятадад хүндрэл ихсэж өөрчлөлт гарсан. Хүний оюун санаанд юу л байна, тэр нь түүний гадаад төрх байдалд нөлөөлөх нь дамжиггүй. Жишээлбэл, хэрэв чи уутанд ямар нэг дөрвөлжин зүйл хийвэл, гаднаас нь хараад чи хэлчихнэ; Хэрэв чи дотор нь ямар нэг бөөрөнхий зүйл хийвэл гаднаас нь хараад л мэдчихнэ. Хүн ямар бодол тээдгийг нь гаднаас нь хараад л мэдчихнэ гэсэн үг юм. Хэн нэгэн миний өмнө зогсож байхад- зөвхөн миний өмнө ч биш, хүний нийгэмд бидний төсөөлж байгаагаас хавьгүй их зүйл бий, олон ер бусын хүч чадвартай хүмүүс байдаг- тэдэнд нэг харц л хүний дотор ямар үзэл бодол, ямар зан чанар давамгайлж байгааг мэдэхэд хангалттай, мөн түүний юунд дуртайг нь шууд мэдчихнэ, учир нь энэ бүхэн хүний нүүрэн дээр нь илэрч байдаг - тэр ч байтугай хүний биеийн хэлбэрээс ч харагддаг.

Тэгвэл, нөхцөл байдал ийм хэцүү байхад та нар хүмүүсийг авралд хүрэхийг хүсвэл юу хийх ёстой вэ? Тэд сайн мууг ялгаж чадахаа больсон, үүний дээр нийгмийн чиг хандлагыг олон нийтэд сурталчлах олон хэвлэл мэдээллийн байгууллагууд байдаг, гэхдээ энэхүү чиг хандлага нь сайн байх албагүй. Хүн бүр ижил зүйл хийж байхад хэвлэл мэдээллийнхэн үүнийг зөвхөн урагш түлхэхэд л тусалдаг. Тэгвэл бодоод үз дээ, хүмүүс яаж сайн мууг ялгах юм бэ? Ялгах арга алга. Бүх хүн төрөлхтний дунд үнэхээр сайхан сэтгэлтэй, зөв бодолтой, энэ бүх нөлөөнд сэтгэл нь автдаггүй хүмүүс цөөхөн байдаг. Тэгвэл бүх зүйл алдагдсан хэрэг үү? Эрт дээр үеэс зохицуулсан бүх зүйлс дэмий хоосон болсон гэж үү? Гэхдээ Гурамсан ертөнц яг л энэ хэргийн төлөө бүтээгдсэн юм. Тэгвэл яах ёстой вэ?

Миний сая хэлсэн нь, торны амыг нээхийг буруу гэж хэн ч хэлж чадахгүй гэсэн үг. Тэгвэл яаж нээх вэ? Хуучин хүчний хөндлөнгийн үймүүлэлийг таслах гэж байгаа бол, хүний ой санамжийг доргиож, юмсыг онцолж ойлгуулж, сэрээж, өнгөрсөн ба өнөөдрийн

дэлхийн үнэнийг тайлбарлаж өгч чадах хүмүүс хэрэгтэй. Хүний нийгэмд аливаа зүйлийг хийхэд үнэхээр хэцүү байдаг, учир нь эерэг талаас нь аливаа нэг алхам хийхэд л хуучин, сөрөг, муу элементүүдийг өдөөж байдаг. Мөн мэдээж эсрэгээрээ бас, сөрөг элементүүдээс ямар нэг алхам хийхэд эерэг элементүүдийг өдөөдөг. Сайн муу хоёр хүн төрөлхтний дунд тэнцвэртэй байдаг бөгөөд энэ ертөнцөд хүн юу ч хийхэд хэцүү байдаг. Хүний энэ ертөнцөд маш олон ер бусын амь бодиуд байдаг, нэг бүр нь хүн төрөлхтөнтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх чадвартай. Тэгвэл, зөвхөн нэг ер бусын амь бодь ийм зүйлийг хийж чадна гэдгийг авч үзвэл, тэд үүнийг яагаад хийдэггүй вэ? Тэд, бүх зүйл өөрийн гэсэн зохицуулалттай байдаг, мөн тэдний хийсэн зүйл хичнээн сайн байх байсан ч хамаагүй, энэ нь өөр ямар нэг зүйлд нөлөөлөнө гэдгийг мэддэг ба тодорхой хардаг, мөн тэр нь модноос мөчрүүд тэлэн ургадагтай адил асар олон зүйлд шууд бусаар нөлөөлнө. Энэ нь дээд бурхдын зохицуулалтыг зөрчиж, нүгэл үйлдэж, тэр ч байтугай хүн төрөлхтний түүхэнд зохицуулагдсан зүйлийг өөрчлөхөд нөлөөлөх болно ---хэн ч хүссэнээрээ өөрчилж зүрхлэх зүйл биш.

Тиймээс яг энэ хугацаанд Дафагийн шавь нар бий болсон. Гэвч орчин үеийн хүмүүс түүхэнд төрөл төрлийнхөө явцад үйлийн үрийн томоохон өрийг хуримтлуулсан байдаг болхоор, хэрэв та нар хүмүүсийг аварч, үнэнийг мэдүүлэхийг хүсвэл тухайн хүнийг аврахыг хүсвэл, түүний ард түүнийг аврагдахыг зөвшөөрөхгүй олон тооны амь бодиуд бий. Учир нь тэдгээр амь бодиуд тэр хүнийг үзэн яддаг, яагаад гэвэл өмнө нь эсвэл өөр ямар нэгэн төрөлдөө түүнд дээрэлхүүлж, түүний гарт амь насаа алдаж, хүчирхийлэлд өртөж, түүнд маш их гомдож, мөн учирсан хор хөнөөл нь тэдэнд асар их зовлон учруулсан байж магадгүй юм. Хүмүүс төрөл төрөлдөө, хуурмаг, хүсэл тэмүүлэлд төөрсөн байхдаа мунхаглалаас болж хийсэн зүйлсийнхээ талаар одоогийн энэ үед юу ч мэдэхгүй. Яг үнэндээ, түүхийн урт хугацааны туршид хүн бүр үйлийн үрийн өрөнд дарагдсан биетэй болсон бөгөөд бүгд төөрөгдөлд оршдог. Хэн нэгэн ийм хүнийг аврахыг үнэхээр хүсч, тэр хүнийг амь бодь гэдгээр нь аврахыг үнэхээр хүсч байвал, тэр хүний хохироосон амь үүнийг тэвчихгүй. Ийм учраас дэлхийн хүмүүсийг аврахын хувьд, тэдэнд үнэнийг ухааруулахаас өмнө хөндлөнгөөс үймүүлж, асар их саад бэрхшээл гарч ирэх болно. Боломжит бүх төрлийн саад тотгорууд гарч ирж хүмүүсийг гацаадаг. Хэрэв та нар олон хүнийг аврахыг хүсч байвал эсвэл та нарын оролдож буй зүйл өргөн цар хүрээтэй байвал, нийгмийн орчин бүхэлдээ ийм үзэгдэлээр бүрдэж ирэх болно.

Эдгээр жилүүдэд хорон муу ХКН Дафагийн шавь нарыг хавчиж байгаа нь зөвхөн хорон муу ХКН-ын хүчин зүйлийн үр дүн биш юм. Үнэн хэрэгтээ эдгээр нь харьцуулбал өрөвдмөөр, өчүүхэн жижиг юм. Сансар ертөнцийн бүх муу элементүүдийг энд нэг бүрчлэн чихэж оруулсан бөгөөд орон зай бүрд тэдгээр нь маш олон, зүгээр л тоо томшгүй олон байгаа. Олон бурхад үүнийг хараад цочирдсон, тэгээд бодсон, "Бид энэ бүгдийг яах ёстой вэ? Хэн үүнд хүрч зүрхлэх юм бэ?" Зөвхөн нэг хүнийг аврах нь сансар ертөнцийн асар их амь бодьтой хамааралтай байдаг. Нөлөөлөл нь ийм том байдаг. Тэгвэл 100 сая хүн ямар том нөлөөг үзүүлэх үү? Та бүхний мэдэж байгаагаар, Есүс хүмүүсийг аварч байхдаа буюу хүмүүсийг аврахын төлөө бүхнээ зориулж байсан боловч, яагаад цовдлогдсон бэ? Есүс зүгээр л өөрийнхөө хүмүүсийг л аварч байсан юм! Түүний хүмүүс төрөл төрлийнхөө туршид үйлийн үрийн өртэй болсон бөгөөд түүнд үүнийг нь шийдвэрлэх арга байгаагүй. Есүст тулгарсан сансар ертөнцийн амь бодиуд бол асар том хэмжээтэй, тоо томшгүй олон, агуу өндөртэй амь бодиуд байсан, үүнээс гадна бүр ч өндөр, зүгээр л хэмжээлшгүй их хувь



хэмжээ бүхий амь бодиуд тэдгээрийн дотор багтсан байсан ---мөн тэд маш том байсан тул дундаж бурхан ч тэдний өндрийг мэдэх боломжгүй байсан-мөн эдгээрийн тоогоор ч тоо томшгүй олон байдаг, хэрэв тэд түүнийг хүмүүсийн өрийг төлөхийг хүсч, төлөхөөс нааш түүнийг чөлөөлөхгүй гэвэл, тэр юу хийж чадах байсан бэ? Хэн ч хэзээ ч өөрийгөө ийм зүйлээс чөлөөлж чадаагүй. Амьдралынхаа төгсгөлд Есүс Еговад хандан "Намайг цовдлолтоос ангижруулж болох уу?" хэмээн гуйсан. Гэвч Егова бас яаж ч чадаагүй. Есүс өөрийн цус, хүний амиараа, зовлон зүдгүүрийг даван туулж байж, тэднийг эргүүлэн төлөхөөс өөр сонголтгүй болсон. Зөвхөн ийм байдлаар л түүнийг чөлөөлсөн. Ийм л хэцүү байсан. Хэрэв Дафагийн шавь нар сансар ертөнцийн амь бодиудыг аврахыг хүсэж байгаа бол, хэрэв тэд нийгмийн энэхүү ээдрээтэй орчинд амь бодиудыг эцсийн шатанд аврахыг хүсэж байгаа бол, энэ нь ямар хэцүү болохыг та нар төсөөлж байна уу? Хэрэв та нар харж чадах байсан бол, үүнийг жинхэнэ харвал, энэ нь зүгээр л аймшигтай байх байсан. Гэхдээ та нар Дафагийн дагуу явж, Багшийн хэлсэн ёсоор явбал, та нарт алхах зам байх бөгөөд энэ нь хэн ч өөрчилж чадахгүй зүйл байх болно. Гэвч энэ зам маш нарийхан байх ба - гагцхүү та нар туйлын зөв байж чадвал, бүх зүйл бүтэж, хүмүүсийг аварч чадна. Гагцхүү аливаа зүйлд туйлын зөв хандаж чадвал, чамд ямар ч асуудал гарахгүй.

Энэ олон жилийн турш энэ замаар явахад тань, багш нь та нарыг харж явж байсан. Би ихэвчлэн богино хэмжээний нийтлэл бичдэг байсан ба үүнийг та нар Жинвэнь гэж хэлдэг. Бясалгалын явцад тань хүн бүрийг байнга засаж, яах ёстойг тань хэлж өгдөг. Хожим нь, би та нарыг цаг хугацаа өнгөрөх тусам боловсорч байгааг тань мэдсэн тул, би байнга бичээд байж болохгүй болсон. Хэрвээ би өмнөхөөсөө илүү хэтэрхий их юм бичээд байсан бол, хуучин хүчнүүд үүнийг тэвчихгүй байх байсан. Багш тэднээс айсандаа биш юм, би тэднийг аливаа зүйлийг илүү төвөгтэй болгохыг нь харахыг хүсэхгүй байна. Хэрэв намайг илүү их зүйл заасан бол, энэ нь чи хийж, чи авч явсантай адилхан болно, ингэж болохгүй гэж тэд үздэг; Энэ нь чамайг өөрийнхөө замаар өөрөө алхаж, өөрөө тэсэж гарах ёстой гэж үздэг. Хуучин хүчнүүд аль хэдийнэ мууг үйлдсэн хэмжээндээ хүрсэн ба Дафагийн шавь нар ийм их сорилт бэрхшээлээс гарч чадаж байгаа нь үнэхээр гайхалтай учираас, би Дафагийн шавь нараас өөрсдийгөө бүтээх энэ боломжийг ашиглахыг хүсмээр байна. Хэрэв та нар энэ хэрэгт сайн ажиллаж чадвал зүгээр л гайхалтай байх болно. Гэвч, хэрэв энэ ажил дуусч, энэ нь төгсгөлдөө ирсэн бол, Дафагийн шавь нарын хувьд энэ нь шударга бус байх болно. Та нарын авардаг хүмүүсийн ард байгаа амь бодиудын бүлгүүд үнэхээр том, тэгвэл ирээдүйд Дафагийн шавь нар яах билээ? Энэ нь бүр өндөр түвшний бүр том амь бодийг, бүр ч агуу бурханыг, тэрнээс ч агуу сүр жавхлантай бурханыг төрүүлэх болно. Хэрвээ хуучин хүчнүүд ийм өндөр биетэй амь бодь бүтээгдэж байгааг харвал, энэ бүхэн та нарыг дагуулж явсан Багшийн ач байсан гэдгийг мэдвэл, тэд та нарыг өөрсдөө үүнд хүрсэн гэж харах байсан болов уу? Тэд та нарыг өөрсдөө энэ замаар явахыг шаардах болно. Тиймээс хуучин хүчнүүдийн тулгасан хүнд сорилтуудыг даван туулахын тулд замдаа зөв явах нь бүр ч хэцүү байдаг. Энэ нь эх газрын Хятад дахь Дафагийн шавь нарын хувьд бүр ч илүү юм. Тэдний хувьд, асар их хатуу хавчлагын дунд бодол болгон нь, санаа бүр нь эгзэгтэй байдаг. Та нар сайн ажилласан эсэхээс үл хамааран; хавчлагад өртөмтгий байх эсэх; чи аливааг зөв зохицуулсан эсэх, хэр зэрэг хавчигдаж байсан эсэхээс үл хамааран, энэ бүхэн та нар өөрсдийнхөө замаар хэрхэн алхсан, аливаа зүйлийн талаар хэрхэн бодож байсантай шууд холбоотой. Дафагийн шавь нарын хувьд бүх зүйл туйлын хэцүү байдаг ба дэлхийн эцсийн энэ үе шатанд, нөхцөл байдал хамгийн ээдрээтэй байгаа энэ үед Дафагийн шавь нар гарч ирж, гарах гарцаа бясалгаж, тэр байтугай бусдыг аварч

байна, Ийнхүү Дафагийн шавь нар өөрсдийгөө ийм агуу, ийм өндөр түвшний оршнолууд болгон бүтээж байна. Та нарын хийж байгаа зүйлд хуучны хүчнүүд саад хийж байгаа учраас үнэхээр гайхалтай бас маш хэцүү байдаг.

Олон энгийн хүмүүс Дафагийн шавь нарын юу хийж байгааг ойлгодоггүй. Энэ нь хэдхэн үгээр тайлбарлачих зүйл биш юм. Хэрэв та нар хэн нэгэнд сансар ертөнцийн үүсэх, тогтох, доройтох, сүйрэх мөчлөгийн эцсийн шатанд ирсэн гэж хэлбэл, тэд та нарт итгэх магадлал тун бага байх болно. Тиймээс бид ийм зүйлийг хэлж болохгүй. Бидний хийх ёстой зүйл бол хүмүүсийг эерэг, эсвэл сайн талаас нь сэрээх явдал юм. Бид тухайн хүнд ямар замаар явах ёстойг нь хэлж шаардаж болохгүй. Харин үнэнийг мэдүүлэхийг ойлгосных нь дараа тэр хүн өмнө нь байгаа хоёр замыг харж, сонголтоо хийх болно. Зарим хүмүүсийн сэтгэхүй нь аймшигтай муухай болчихсон байдаг ба тэд сайн зүйлийг хүлээж авахаа больсон. Ийм хүмүүс угаасаа муу муухай, хорон муу, орчин үеийн, гажуудсан зүйлийг сонгож, хуучин сансар ертөнцийг дагадаг. Зөвхөн сэрэх чадвартай, ирээдүйд ямар амьдралын замналаар явах ёстойгоо ухаарч чаддаг, хүмүүс юуны төлөө энэ ертөнцөд ирснийг ойлгодог хүмүүс л - зөвхөн иймэрхүү төрлийн хүмүүс л үнэхээр аврагдаж чадна.

Надаас ингэж асууж байсан, “Хэзээ нэг өдөр Фа-цэвэрлэгээ дууссаны дараа, дараагийнх нь хүний ертөнцийн Фа-цэвэрлэгээ байх болно. Ирээдүй ямар байх бол?” Үүнд би, “Хүмүүс хэнтэй ч тааралдсан тэр хүнтэйгээ дотно байх болно” гэж хариулсан. “Өө” гэсэн, тэгээд тэд “энэ нь хүмүүсийн ёс суртахууны үнэлэмж сайжирна гэсэн үг, гайхалтай” гэж бодсон. Үнэндээ тэд үүнийг ингэж л ойлгож чадна. Хүмүүсийн ёс суртахуун хэр их дээшилсэн байх нь хамаагүй, яагаад хүмүүс тааралдсан хүнтэйгээ тийм дотно байна гэж? Энэ нь ихэвчлэн хэдэн арван милийн зайн цаана ч өөр хүнийг олж харахгүйтэй холбоотой байж болох юм. Тиймээс тэд харсан хүнтэйгээ ойр дотно байх болно. Би та нарт хэлье, тэд ямар ч шашинтай байсан – Буддын шашин, Бумбын шашин, Христийн шашинтай байх хамаагүй, эсвэл та нарын мэддэг олон зөгнөл, эсвэл ямар ч байсан бүгд өнөөгийн ертөнц ямар байх талаар ярьж ирсэн. Зарим хүмүүс, [тэдгээр зөгнөлүүд юуны тухай өгүүлдэг] нь одоо ч гэсэн хамаагүй хол байна гэж бодон тэднийг үгүйсгэдэг. Энэ нь үнэн байж магадгүй юм. Тэд өөрсдийн итгэдэг зүйлээрээ явах нь сайн хэрэг. Гэвч Дафагийн шавь нар амлалтаа биелүүлж байна, мөн хүмүүсийг сэрээхийн тулд чадах бүхнээ хийж байна гэсэн үг юм.

Та бүхний мэдэж байгаагаар хүн төрөлхтөн түүхэнд хэзээ ч ийм эмх замбараагүй, ийм хэмжээнд хүртлээ төвөгтэй байж байгаагүй. Хүн үүнийг шинжлэх ухаан, технологийн дэвшлийн үр дүнд [энэ цэгт хүрсэн], энэ нь хүний нийгмийн дагадаг жам ёсны зам гэж боддог. Гэхдээ аливаа зүйл санамсаргүй байж болох уу? Шинжлэх ухаан ба технологи, хүний уламжлал нь хүний нийгэмд нэгэн зэрэг оршдог хоёр өөр явц юм. Та нар аль явцыг сонгож, аялах нь хүнд өгөгдсөн сонголт юм. Би зүгээр л, сайн ба муу нь хүн бүрийн сонголт хийх зүйл бөгөөд энэ хоёр чиглэлийг ирээдүйд хүн төрөлхтөнд үлдээх болно гэдгийг л хэлээд байгаа юм. Орчин үеийн сэтгэлгээний нөлөөнд автсан олон хүмүүс бурханлаг зүйлээс салахыг хүсч, хүнийг бурхан бүтээсэн гэдгийг хүлээн зөвшөөрөхөөс татгалздаг. Хүмүүс өөрсдийгөө хүчирхэг гэж боддог ч, өчигдрийн хар салхинаас харахад хүн байгалийн хүчний өмнө үнэхээр өчүүхэн юм. Хэрэв сансар ертөнцийн сүйрэл үнэхээр ирэх юм бол, тэр дуусна. Түүгээр ч зогсохгүй, хэрэв хүний шинжлэх ухаан ба технологи нь эрчим хүчний эх үүсвэрээ алдах юм бол, өнөөгийн нийгэм тэр даруй саажилттай болж,

орчин үеийн шинжлэх ухаан ба технологи нэн даруй сүйрэх болно. Технологи нь гайхалтай дэвшилттэй харь гаригийн аминий хэлбэрүүд хүртэл үүсэх, тогтох, доройтох, сүйрэх сансрын мөчлөгийн дунд Фа-цэвэрлэгээгээр авралыг эрэлхийлэх ёстой.

Тиймээс энэ нь хүн төрөлхтний өмнө тавигдсан зүйл юм. Гэвч ийм ээдрээтэй ертөнцөд хүмүүсийг аврах нь Дафагийн шавь нарт үнэхээр хэцүү байдаг. Магадгүй та нар заримдаа ийм зүйлсийг тунгаан бодоход хэтэрхий завгүй байдаг ч, Багш аливааг маш тодорхой байдлаар хардаг. Тийм ч учраас би байнга боддог: “Дафагийн шавь гэж юу вэ? Хэн Дафагийн шавь байх зохистой вэ?” Хэрэв хэн нэгэнд шаардлагатай хувь заяаны холбоо байхгүй бол тэр үнэхээр орж чадахгүй бөгөөд энэ нь дөнгөж орж ирсэн хүмүүст ч ялгаагүй. Хавчлага болон Дафагийн шавь нарын тухай ёс бус ХКН-ын худал яриа энэ олон жилийн турш хүмүүсийг орж ирэхэд саад болсон юм биш. Тийм биш юм. Хүмүүс байнга л орж ирж байсан биз дээ? Тиймээс энэ нь шалтгаан биш юм. Түүнээс гадна, муу ёрын ХКН-г муу гэдгийг нь бүгд мэднэ. Олон хүмүүс үүний хэлсэн зүйлд үнэхээр итгэдэггүй. Жинхэнэ шалтгаан нь, тэдгээр бурхад хүмүүсийг Дафагийн шавь болохыг зөвшөөрөөгүй, хааж байсан явдал юм. Хэрэв тэр зохистой биш бол тэд хэнийг ч оруулахгүй. Энэ нь хүмүүс өөрсдөө үүний нэг хэсэг болохыг хүсэхгүй байгаагаа илэрхийлснээр илэрдэг; эргэн тойрон дахь нөхцөл байдал нь тэднийг орж ирэхэд нь саад болдог, хүн ингэж ч нэг ярьж, тэгэж ч нэг хэлж, тэднийг битгий яв гэдэг; тэднийг зовоож буй зүйлсийг хойш тавьж чаддаггүй; эсвэл ийм ч хэцүү тийм хэцүү, эсвэл энэ ч бүтэхгүй байна, тэрийг ч орхиж чадахгүй байна зэргээс болдог. Тиймээс энэ бүхэн нь тэднийг орж чадахгүйд хүргэдэг.

Тийм ээ, та нар үүнээс ямар нэг зүйлийг ойлгож байна уу? Та нар бол Дафагийн шавь нар, дээрх тоо томшгүй олон амь бодиуд, тооны хувьд бол зүгээр л хязгааргүй оршихуйнууд та нараар бахаддаг. Хэрэв би өнөөдөр аль нэг дээд түвшний бурханд, түүний ямар агуу байх нь хамаагүй, ирж Дафагийн шавь болох боломжийг санал болговол, тэр секундын дотор боломжоороо үсэрч ирэх болно ---Миний үгс түүнд хүрэх агшинд тэр ирэх болно. Энэ нь зөвхөн өөрийгөө төдийгүй өөрийнхөө ертөнцийн тоо томшгүй олон амь бодиудыг аварч чадна гэдгийг хэн бүхэн мэддэг учраас тэр зүгээр л баяртай байх болно. Энэ бол ирээдүйн сансар ертөнцийн хамгийн ер бусын зүйл юм. (Алга ташилт) Гэвч энэ нь боломжгүй. Дафагийн шавь нар түүхийн туршид энэ ертөнцөд олон төрлийнхөө явцад зайлшгүй хүчирхэг буянаа бүтээцгээсэн. Дафагийн шавь нарын дасгалаа хийдэг газруудад эхэндээ олон хүн ирдэг байсан. Гэхдээ дасгал дууссаны дараа нүд ирмэхийн зуур алга болчихдог байсан, тэдний зарим нь хэн болохыг хэн ч мэдэхгүй. Олон бурхад Дафагийн шавь болохыг үнэхээр хүсдэг ч, чадахгүй.

Дафагийн шавь нар энгийн хүмүүстэй мөр зэрэгцэн амьдралаа зохиож, хуурмаг эгэл жирийн нийгмийн нэг хэсэг болж амьдардаг, хамгийн наад зах нь зарим талаараа бодол нь олны сохроор дагадаг урсгалд өртөмтгий байдаг. Хэрэв чи аливаа зүйлийг хийхдээ Дафагийн дагуу биеэ авч явж чадахгүй байвал, зөв бодлоор аливааг эргэцүүлэн бодож чадахгүй бол, эсвэл асуудлыг авч үзэхдээ Фа дээр байхгүй бол, чи энгийн хүн л гэсэн үг. Тэгвэл ямар ч ялгаа байхгүй. Чиний гаднах төрх энгийн, чиний амьдарч буй орчин энгийн, ажил чинь энгийн. Чи Дафагийн шавь нарын төслүүдэд оролцож байсан ч гэсэн, тэнгэрт телевиз гэх мэт зүйл байдаггүй, бурхадад сонин ч гэж байдаггүй. Эдгээр нь энгийн хүний нийгэм дэх хэлбэрүүд юм. Хэрэв чи өөрийгөө удирдан чиглүүлэхийн хувьд зөв бодлуудыг

ашигладаггүй бол, мөн Дафагийн шавь шиг өөрийгөө авч явж, ертөнцийг болон бусдыг бясалгагчийн жишгээр харж чадахгүй бол, тэгвэл чи энгийн хүнтэй л адилхан.

Бясалгагч гэж юу вэ? Хүмүүс үсээ хусуулж, сүм хийдийн амьдралаар явах юм бол, бурханлаг амь болно гэж үздэг зуршилтай болсон. Гэхдээ энэ нь зөв байж чадах уу? Огт үгүй. Энэ нь зөвхөн энгийн хүмүүс эсвэл бусад хүмүүсийн гадаад төрхийн л ялгаа юм. Мөн энгийн хүмүүс тэднийг өөр гэж хардаг байсан. Тэгээд дараа нь тэд сэтгэлээ бясалгадаг, учир нь тэд нийгэмд бохирдсон зүйлс болон "долоон сэтгэл, зургаан хүсэл" гэж нэрлэгддэг зүйлсийн дунд амьдарч байсан тул тэдний сэтгэл нь энгийн хүмүүсийнхтэй яг адилхан байдаг. Гэхдээ энэ нь зөвхөн эдгээрээр хязгаарлагддаг уу? Орчин үеийн нийгэмд энэ нь зөвхөн долоон сэтгэл, зургаан хүсэл биш болсон, харин бүр далан сэтгэл, жаран хүсэлтэй адил болсон, тиймээ? Бүх төрлийн хүсэл эрмэлзэл байдаг. Хүмүүсийн компьютер, гар утас, iPod гэх мэт зүйлст зууралдсан сэтгэл хөдлөлийг нь авч үзье - урьд өмнө ийм зүйл байсан юм уу? (Хүмүүс инээв) Өнөөгийн нийгэм ийм байгаа болохоор, бүх зүйл илүү төвөгтэй болсон. Ямар ч төрлийн бясалгалын хэлбэр нь зөвхөн өнгөц хэлбэр төдий байсан. Дафагийн шавь нарын бясалгал, та нарын хүрээлэн буй орчин, бясалгалын газар бүгд нийгэмд нээлттэй. Нэгэнт хүний нийгэм бүхэлдээ Фа-цэвэрлэгээний зорилгоор бүтээгдэж, бүрэлдэн тогтсон болохоор бодоод үз дээ, нийгэмд тулгарч буй асуудлууд нь харагдаж байгаа шигээ энгийн байж чадах уу? Хүн ямар ч ажил, мэргэжилтэй байсан бясалгаж болно гэдгийг би та бүхэнтэй өмнө нь хуваалцаж байсан. Үнэндээ, та нарт тулгарч буй зөрчилдөөн, хурцадмал байдал эсвэл энэ бүхэн та нарын сэтгэлийг шалгах зорилготой бөгөөд харна: Чи үүнийг бясалгагчд тохирсон байдлаар зохицуулж чадах уу? Чи үүнийг хэрхэн зохицуулж байгаа нь Дафагийн шавийн хувьд зохистой юу? Бясалгал гэж юу болох нь энийг л хэлээд байгаа юм, тийм биз дээ? Энгийн хүмүүс ийм байдлаар асуудлыг шийдэж чадах уу, эсвэл ийм байдлаар харж чадах уу? Зөрчилдөөнтэй тулгарах үед чиний зөв байх эсэх нь хамаагүй. Чи өөрөөсөө асуух хэрэгтэй, "Энэ нөхцөл байдалд миний юу буруу байна вэ? Үнэхээр надад ямар нэг зүйл буруу байгаа юм болов уу?" Та нар бүгд ийм байдлаар бодож байх хэрэгтэй, чиний хамгийн түрүүний бодол асуудлыг олохын тулд өөрийгөө сайтар нягталж үзэх хэрэгтэй. Ийм биш хэн ч байсан үнэндээ Дафагийн жинхэнэ бясалгагч биш. Энэ бол бидний бясалгалын ид шидийн дохиур юм. Энэ бол манай Дафагийн шавь нарын бясалгалын ялгарах онцлог юм. Та нарт юу ч тохиолдсон бай, хамгийн түрүүнд өөрийгөө нягталж үзэх хэрэгтэй бөгөөд үүнийг "дотогшоо харах" гэж нэрлэдэг. Буддын шашин ч бас ийм хандлагыг баримталдаг. Тэд "сэтгэлийн бясалгал"-ыг заадаггүй гэж үү? Дотогшоо хардаг уу? Тэд бас энэ талаар ярьдаггүй гэж үү? Хэдийгээр тэд энэ талаар нэг их юм яридаггүй, гол асуудлыг хөнддөггүй ч, адилхан л ярьдаг.

Миний сая ярьсан бүх зүйл нь үнэндээ Дафагийн шавь нарын үүрдэг хариуцлага асар их гэдгийг та нарт хэлэх гэсэн юм. "Дафагийн шавь" гэж юу вэ? Бидний сүүлчийн Фа чуулганаас хойш тийм ч удаан хугацаа өнгөрөөгүй байна. Хэдийгээр би хамгийн сүүлд олон тооны сурагчидад тулгардаг зарим нэг асуудлыг сайн сурч байгаа эсэхээс үл хамааран зарим нэг явцтай холбоотой асуудлыг хөндсөн. Ийм учраас бид сүүлийн Фа чуулганаас хойш хүмүүс ямар байдалтай байсныг ярихгүй. Дафагийн шавь нар Багшийн Фа-сургаалыг сонсох нь шинэ зүйл мэтээр үзэж, Багшаас шинэ илчлэлтүүд болон сонирхолтой зүйлсийг сонсох ёсгүй гэдгийг би хэлье. Мэдээж, та нар үүнийг ингэж

бодохгүй байх болно. Гэхдээ үнэхээр, Багш ярьж дууссаны дараа та нар энэ тухай эргэцүүлэн бодох хэрэгтэй. Дафагийн шавь нарын хувьд та нар үүнийг бодох хэрэгтэй.

Одоогоор хамтран ажиллах тал дээр аймаар дутагдалтай зарим сурагчид байсаар байна. Зөвхөн зүгээр нэг дутагдалтай ч биш, бүр бие биенээ хорлон сүйтгэх хэмжээнд хүрч байна. Чи ямар бодолтой байгаагаас үл хамааран, Дафагийн шавийн төсөл эсвэл Дафагийн шавь нарын хийх ёстой ямар нэг зүйлийг хорлон сүйтгэхийн тулд үйлчилдэг бол, чи чөтгөрийн үүрэг гүйцэтгэж байгааг би чамд хэлье. Чи “Би Дафагийн шавь, би маш их зүйл хийсэн” гэж бодож байгаа чинь хамаагүй. Хуучин хүчнийхэн чиний бүртгэл тооцооны дэвтэрт нэг нэгээр нь бичилт хийж байна.

Та нар мэдэж байна уу? Дафагийн шавь нар аа, та бүхний зөв бодол үнэхээр нөлөөлдөг. Мөн та нарын нэг бүрийн хамтын үр нөлөө нь юутай ч зүйрлэшгүй хүчтэй байдаг. Та нар ийм үр дүнд хүрч чадахгүй байгаа шалтгаан нь та нарын итгэл дутмаг, зөв бодол тань хангалттай хүчтэй биш байгаа явдал юм. Дэлхий даяар маш олон Дафагийн шавь нар нэгэн зэрэг ариуслын бодол гаргаж, 100 сая гаруй Дафагийн шавь нар нэгэн зэрэг ариуслын бодлыг дэлхий даяар гаргаж байгаа нь хорон муу болон хуучин хүчнийхний хувьд, аймшигтай биш гэж үү? Бурхадын хувьд энэ нь үнэхээр гайхалтай үзэгдэл байх болно. Ямар хүчирхэг гээч! Тэр битгий хэл зөвхөн нэг Дафагийн шавь байсан ч, чиний ариуслын бодол хүчтэй байвал, хүч чинь уулыг хуваахад хангалттай—зөвхөн ганц бодол үүнийг хийх болно. Энд байгаа хуурмаг байдлын дор, чи өөрийн хүчийг мэдэрч чадахгүй, гэхдээ энэ нь тийм ч чухал биш юм. Хамтдаа сайн ажиллахгүй, зөв бодол тань хангалттай хүчгүй байвал, энэ нь сэтгэлд тань нөлөөлж, үүний зэрэгцээ бясалгалд чамайг дотогшоо бус, гадагшаа харахад хүргэдэг зууралдсан сэтгэлүүд дээр төвлөрөхөд хүргэнэ. Энэ нь чамайг хэн нэгний тухай бодох болгондоо зэвүүцүүлж, дэлбэртлээ уурлахад хүргэдэг. Тэгвэл надад хэлээдэх дээ, чи ингэж ариуслын бодол гаргах нь ямар учиртай юм бэ? Тэд эерэг үр дүнд хүрэхгүй бөгөөд чи өөрийн бүх бодол санаа, үзэл бодол, зууралдсан сэтгэлээ бүхэл сансар ертөнцийн бурхадад илчлэх болно. Энэ бодол гарахад, энэ бүхэн сансар ертөнцөд харагдахаар тавигдаж, чамайг ямар байгааг бүгд харах болно. Бодоод үз дээ, хэрэв хуучин хүчнүүд чамайг хавчаагүй бол хачирхалтай байх болно. Тиймээс тэд чамайг хавчихад, Багш яаж ч чадахгүй, учир нь тэдэнд барьж авах бариул байдаг: “Энэ амь бодийг хар даа, тэр ямар байгааг нь хар даа. Энэ чиний шавь мөн юм үү? Тэр үнэхээр дутуу байна. Бид түүнийг шулуутгах ёстой биш гэж үү? Чи түүнийг шулуутгахыг хүсэхгүй байгаа ч, тэр бидэнд нөлөөлж, бусдад нөлөөлж байгаа болохоор, бид түүнийг хурдан шулуутгасан нь дээр!”. Би юу боддог вэ гэхлээр: Дафагийн шавь нар та бүхний өмнө цорын ганц л зам байна, энэ нь жинхэнэ бясалгалын зам юм. Өөр зам байхгүй.

Эх газрын Хятад дахь Дафагийн шавь нар хавчлагын дунд улам сэтгэлээ жолоодож, саруул болж, улам бүр сайжирч байгааг би саяхан харсан. Гэсэн хэдий ч нөхцөл байдал сайжрахын хэрээр дэлхий даяарх Дафагийн шавь нар бага зэрэг суларч байна. Зарим хүмүүс хамтрах нь бүү хэл, юу ч хийсэн урам зориггүй юм шиг байдаг. Тэд хамтран ажилладаггүй, бие биетэйгээ тэмцэлддэг, бусдын санаа бодлыг хүлээж авах дургүй, тэр ч байтугай үг яриа, байгаа байдлаараа үнэхээр бүдүүлэг байдаг. Тэд үнэндээ Дафагийн шавь шиг биш. Үүнийг хараад Багшийн зүрх сэтгэл өвддөг. Та нар хамгийн хатуу хавчлагыг туулсан, бурхад та нараар бахдаж байгаа ч та нар үүнийг нандигнахаа мэдэхгүй байна. Бид

төгсгөлийн сүүлийн шатанд ирсэн тул, та нарын туулж өнгөрүүлсэн зүйл дахин давтагдахгүй. Би хэдхэн хормын өмнө олон хүн Дафагийн шавь болохыг хүсч байгаа ч, одоо ороход маш хэцүү байгаа гэж хэлсэн. Өөр нэг шалтгаан бий, хамгийн том нь юм, тухайлбал, Дафагийн шавь нарыг онилсон хамгийн хатуу сорилт, хавчлага аль хэдийн сүүлний төгсгөлдөө хүрсэн. Дэлхийг бүхэлд нь залгисан асар их дарамт, бэрхшээл, эсвэл та нар бясалгах зоригтой эсэх, зөв замаар явж чадах эсэхээ шалгуулдаг сорилт гэхчилэн түүхийн тэр хэсэг өнгөрч, одоо байхгүй болсон. Дафагийн шавь болохыг хүссэн хэн бүхэнд хуучин хүчнийхэн маш хатуу хориг тавих болно. Тэд хүмүүсийг оруулахгүйн тулд чадах бүхнээ хийх болно. Та нар ийм хүнд хэцүү нөхцөл байдлыг үл харгалзан үүнийг даван туулж, өөрсдийгөө гайхалтай гэдгээ нотолсон. Та нарын авах ёстой агуу буян аль хэдийн та нарынх болсон. Энэ үед суларч, өөрсдийгөө доошоо гулсахыг зөвшөөрөх нь үнэхээр тохиолдох ёсгүй зүйл юм.

Амь бодиудыг аврах, үнэнийг мэдүүлэхийн хувьд, олон хүмүүс үүнийг гүнзгийрүүлж хийхгүй байна. Тэд хүмүүст хэдхэн үг хэлчихээд, боддог "Сонсоно уу байна уу, дураараа бол. Чи сонсохыг хүсэхгүй байна, тэгвэл тэр л биз!" тэгээд тэд дараагийн хүнийг хайж олохоор явна. Юу ч хийсэн бай та нар үүнийг эцэс хүртэл нь хийж, сайн хий, хэрэв та нар хэн нэгнийг аврах гэж зориж л байгаа юм бол цааш явж, түүнийг аврах хэрэгтэй. Хэн нэгэн чиний өмнө ирсэн л бол сонголт байхгүй - хэрэв чи хүмүүсийг аврах тал дээр сонголт хийвэл чи буруудах болно. Тэр хүн чамтай тааралдсан л бол албан тушаал, нийгмийн үнэлэмж, ерөнхийлөгч ч бай, гуйлгачин ч бай, аль нь ч хамаагүй түүнийг аврах хэрэгтэй. Бурхдын мэлмийд амь бодиуд тэгш байдаг. Нийгмийн үнэлэмж бол зүгээр л хүний нийгэмд бий болсон ялгаа л юм. Дафагийн шавь нар бүгд хуучин цагт бие биетэйгээ хамт байсан шигээ, та нарыг анх Фа-г олж авах үеийнх шигээ хичээнгүй байж чадна гэдэгт би найдаж байна. Буддын шашны сургаал байдаг, санаа нь: Хэрэв чи эхнээсээ эцсээ хүртэл дөнгөж эхэлсэн шигээ байж чадвал, төгс төгөлдөрт хүрэх нь гарцаагүй. (Алга ташилт)

Та нар энгийн хүний нийгмийн дунд бясалгаж, Фа чуулганд оролцож, бие биетэйгээ санал бодлоо хуваалцаж, солилцож болно. Гэхдээ агуйд бясалгадаг хүмүүс бясалгалдаа бүтэлгүйтвэл тэндээ үхдэг гэдгийг та нар мэднэ. Тэдэнд юу тохиолдсон талаар ярилцах хүн байдаггүй, ярих хүн ч байдаггүй. Тэд өөрсдөө зөв гэгээрэх замаар үүнийг даван туулах ёстой байдаг. Хэрэв тэд үүнийг даван туулж чадаагүй бол тэд дууссан гэсэн үг. Энэ ямар хэцүү гээч! Хамгийн аймшигтай нь удаан үргэлжилэх ганцаардал байдаг. Хүмүүс юунаас хамгийн их айдаг вэ? Ганцаардлаас. Ганцаардал нь хүнийг галзууруулдаг; ганцаардал нь хүнийг өмнөх бүх зүйлээ мартахад хүргэдэг; ганцаардал нь хүнийг яаж ярихаа мартахад хүргэдэг. Энэ бол зовлонгийн хамгийн аймшигтай хэлбэр юм. Хүмүүс хэн нэгнийг есөн жил, 13 жил, зарим нь зуун жил хана өөдөөс харан суусан гэх мэтчилэн ярьдаг. Та нарт ийм ганцаардал байхгүй. Та нар зүгээр л эхнээс нь дуустал тууштай байж Дафагийн шавь шиг байх ёстой.

Багш өнөөдөр та нарт бага зэрэг хатуу хандлаа. Энэ нь та нарыг илүү сонор сэрэмжтэй, сэргэг байхад тань туслах зорилготой байлаа. Та нар дэлхийн хүмүүсийг аврахыг эрэлхийлэхдээ тэднийг аврахын тулд сэрээхийг оролддог. За, та нар ч гэсэн бас саруул ухаантай байж, сэрэх хэрэгтэй. Хэрэв та нар хэтэрхий олон зүйл хийснээс болж бясалгалаа мартвал энэ нь асуудал болно. Та нар бол бясалгагчид. Би та нарын өнгөрсөн, урьд нь юу байсан, эсвэл өнгөн дээрээ юу харуулж байгааг чинь яриагүй байна. Би та

нарын амьны гол цөм, утга учир, үүрч буй үүрэг хариуцлага, түүхэн эрхэм зорилгын тань тухай ярьж байна. Зөвхөн ийм байдлаар л та нар жинхэнэ Дафагийн шавь юм.

Та нарын зарим нь олон төсөл хөтөлбөрт маш сайн оролцож, хүмүүсийг аварсан, ерөнхийдөө та нар маш сайн ажиллаж, том нөлөө үзүүлсэн гэдгийг би мэднэ. Та нар Багшид Фа-г засч залруулахад туслахын тулд хийх ёстой зүйлээ хийсэн гэдгийг би ойлгож байна. Та нарыг илүү сайн хийж чадна гэж найдаж байна. Бидний зам бол маш нарийхан. Хэрэв та нар замаасаа бага зэрэг хазайвал, асуудал гарах болно. Би та нарын асуудалтай тулгарахыг тань харахыг хүсэхгүй байна, мөн хэнийг ч бясалгалдаа доошоо гулсахыг хүсэхгүй байна. Нөхцөл байдал сайн тал руугаа өөрчлөгдөж байгаа учраас, би та нарыг бясалгалдаа суларч байгааг харахыг бүр ч хүсэхгүй байна. Энэ бүхнийг та нар бүтээсэн бөгөөд цаашид олон зүйл хүлээж байна, энэ нь та нарыг Төгс төгөлдөрт хүрэх өдрийг хүртэл үргэлжилсээр байх болно. Та нар хамгийн хэцүү үеийг аль хэдийн даван туулсан. Үлдсэн зүйл нь тийм ч хэцүү биш байх болно. Та нар үүнийг илүү сайн хийх хэрэгтэй. Илүү найдваргүй зүйл мэт санагдаж магадгүй байх тусам, найдвар та нарын нүдний өмнө гарч ирэх боломжтой. Хэдий чинээ залхмаар байна, төдий чинээ агуу буянаа бүрдүүлнэ. Та нар үнэхээр сайн хамтран ажиллаж чадна, хангалттай хүчтэй зөв бодолтой байж, аливаа зүйлтэй тулгарах үедээ дотогшоо харж, анх бясалгаж эхэлсэн үеийнхээ адил урам зоригтой байж чадна гэдэгт найдаж байна. Түр зуурын урам зориг нь хэдхэн минутын дараа алга болж, дараа нь бүрмөсөн алга болдог энгийн хүмүүс шиг битгий бай.

Хамтдаа ажиллаж байхдаа маргаантай тулгарах нь хүний зууралдсан сэтгэлтэй холбоотой байдаг. Энэ нь хүний бясалгалын төлөв байдал, үйл явцын нэг хэсэг бөгөөд та нарын хэн ч үнэхээр сайн биш гэсэн үг огтхон ч биш юм. Хүний сайн тал нь үл үзэгдэж, тусгаарлагдчихдаг. Чиний харж байгаа зүйл үргэлж бясалгаж амжаагүй тал нь байх болно. Гэхдээ энэ нь та нар энэрэнгүй сэтгэлтэй байж болохгүй, эсвэл хүмүүсийг хатуу нүдээр харах хэрэгтэй гэсэн үг биш юм. Чи тухайн бясалгагчийн сайн талыг харж чадахгүй гэж би дахин дахин хэлсэн. Тухайн тал нь зүгээр л гайхалтай бөгөөд шалгуурыг хангасан байдаг. Мөн “шалгуурыг хангана” гэдэг нь юу гэсэн үг вэ? Энэ бол бурхны шалгуур юм. Түүний харахан амжилттай бясалгаж амжаагүй хэсэг нь дээшилж, гадаргуу руу ойртох тусам улам дордох болно. Гэхдээ тэр хүн их сайн бясалгасан байж магадгүй. Та бүхэн өөрсдийгөө эрхэмлэж, бусдыг эрхэмлэж, өөрт байгаа энэ орчноо эрхэмлэнэ гэдэгт найдаж байна. Аялж буй замаа эрхэмлэх нь өөрсдийгөө дээдлэх явдал юм.

Миний хэлэх зүйл ингээд дууслаа. Та нарын Фа чуулган бүрэн амжилттай болно гэдэгт найдаж байна. Хуралд олон хүмүүс өөрсдийн бясалгалын явц, бясалгалын төлөв байдал, Дафагийн шавийн зөв бодлуудтай тулгарсан янз бүрийн зүйлд хэрхэн хандсан тухайгаа хуваалцах болно. Та нар эдгээр зүйлийг сонсохдоо тэдэнд зүгээр нэг өгүүлэл мэт хандаж болохгүй. Энэ бол хэн нэгний бясалгалаар алхсан зам, мөн та нарын туулсан зам юм. Та нарын урам зориг сэргэж, хамгийн сайн бясалгалын төлөвтөө эргэн орохыг харна гэж найдаж байна. Өнөөдөр би яриагаа ингээд дуусгая. Та бүхэнд баярлалаа.

(Бүгд босож, нижигнэтэл алга ташив.)